

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаанбаатар смарт карт” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/030/НА-СТА-ОНӨТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.15 № 012
танай _____ -ны № _____ -т

“УЛААНБААТАР СМАРТ КАРТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.РАГЧАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар смарт карт” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар хотын Улаанбаатар смарт карт ХХК 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улаанбаатар смарт карт ХХК-ны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 195.5 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 8,736.2 сая төгрөгөөр, зардлыг 10,391.8 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 9,210.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11,150.0 сая төгрөгийн зардал гаргаж 1,939.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Bwax xppar 2026\2026\word\ywaan_bichig\Dugnell 2026.docx

1426050955

Аудитын гол асуудал

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/13 дугаар тогтоолоор “Улаанбаатар смарт карт” ХХК-д эзэмшиж бусад хувьцаа эзэмшигчдээс 79.0 хувийн хувьцааг худалдан авч Нийслэл 100.0 хувийн хувьцаа эзэмшигч болсон байна. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\naranga\Desktop\Bseur\kapat\2026\028\word\ywan\biqip\Ougnet\ 2026.docx

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,912,978,352	3,803,888,733.17
1.1.2	Дансны авлага	145,548,369.65	333,330,307.66
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	151,998,143.61	199,588,912.96
1.1.4	Бусад авлага	360,911,020.97	215,674,637.73
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,582,575,616.44	
1.1.6	Бараа материал	531,053,220.92	794,641,423.18
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	579,187,286.74	188,829,541.41
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	792,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,264,252,010.02	6,327,953,556.11
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,754,578,886.57	14,414,895,471.14
1.2.2	Биет бус хөрөнгө	3,067,088,281.75	2,929,371,524.03
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө-барьцаа	4,139,510.00	650,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,826,806,678.32	17,345,916,995.17
1.3	Нийт хөрөнгийн дүн	12,091,058,688.34	23,673,870,551.28
2.1.1.1	Дансны өглөг	6,309,249,668.75	6,560,881,785.50
2.1.1.2	Цалингийн өглөг	3,950,934.21	2,642,368.49
2.1.1.3	Татварын өглөг	200,386,140.59	13,941,599.17
2.1.1.4	НДШ-ийн өглөг	39,905,366.55	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,397,892,636.92	17,542,888,765.95
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,256,170,008.69	5,635,204,675.62
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	16,207,554,755.71	29,755,559,194.73
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	70,490,433	44,690,433
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	70,490,433.00	44,690,433.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	16,278,045,188.71	29,800,249,627.73
2.3.1	Өмч: а) төрийн	438,000,000.00	1,825,000,000.00
2.3.2	б) хувийн	1,387,000,000.00	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	38,384,439,675.00	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(44,396,426,175.37)	(7,951,379,076.45)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(4,186,986,500.37)	(6,126,379,076.45)
2.4	Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн	12,091,058,688.34	23,673,870,551.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
1	Борлуулалтын орлого /цэвэр/	7,497,460,042.68	8,615,642,492.47
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,351,052,728.00	6,759,515,831.74
3	Нийт ашиг (алдагдал)	146,407,314.68	1,856,126,660.73
5	Хүүгийн орлого	189,356,355.33	288,676,744.78
8	Бусад орлого	3,924,033,288.46	306,315,038.19
9	Борлуулалт маркетингийн зардал	86,244,138.45	75,101,169.04
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,239,030,886.86	3,821,633,472.65
11	Санхүүгийн зардал	1,065,377,989.87	-
12	Бусад зардал	4,455.00	2,982,255.44
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	173,043,747.91	461,938,187.61
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	16,908,552.48	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(320,812,812.10)	(1,910,536,641.04)
19	Орлогын татварын зардал	75,218,556.32	28,855,935.04
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(396,031,368.42)	(1,939,392,576.08)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(396,031,368.42)	(1,939,392,576.08)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	38,384,439,675.00	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,431,601,760.13	44,710,222,582.76
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	7,351,570,705.97	8,409,196,129.87
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,028,296.46	1,329,768.00
	Бусад мөнгөн орлого	33,076,002,757.70	36,299,696,684.89
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	40,093,348,191.11	44,297,182,082.21
	Ажиллагчдад төлсөн	1,834,763,098.44	2,361,346,330.45
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	417,797,840.52	568,083,495.33
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,256,323,685.16	2,158,342,246.94
	Ашиглалтын зардалд төлсөн	45,310,667.35	39,995,644.97
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	43,602,944.65	81,612,066.08
	Хүүгийн төлбөрт төлсөн	507,240,711.64	-
	Татварын байгууллагад төлсөн	422,545,954.42	704,311,044.81
	Даатгалын төлбөрт төлсөн	13,834,977.48	1,468,260.00
	Бусад мөнгөн зарлага	35,551,928,311.45	38,382,022,993.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	338,253,569.02	413,040,500.55
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	193,351,454.97	446,110,797.17
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,960,000.00	-
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		154,789,200.00

	Хүлээн авсан хүүгийн орлого	191,391,454.97	291,321,597.17
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	901,130,170.93	1,470,615,279.17
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	710,574,564.49	553,190,895.60
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,979,990.00	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	182,575,616.44	917,424,383.57
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(707,778,715.96)	(1,024,504,482.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,500,000,000.00
	Бусад мөнгөн орлого		2,500,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	2,500,000,000.00
3.4	Валютын ханшийн зөрүү	(6,645,492.15)	2,374,362.93
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(376,170,639.09)	1,890,910,381.48
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,289,148,990.78	1,912,978,351.69
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,912,978,351.69	3,803,888,733.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	1,825,000,000.00	(44,396,426,175.37)	(42,571,426,175.37)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		38,384,439,675.00	38,384,439,675.00
3	Залруулсан үлдэгдэл		(6,011,986,500.37)	(6,011,986,500.37)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(1,939,392,576.08)	(1,939,392,576.08)
9	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,825,000,000.00	(7,951,379,076.45)	(6,126,379,076.45)

2.5 Зорилтот түвшиний төлөвлөгөө, гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	8,479,343,497.97	8,921,957,627.26	(442,614,129.29)	105.2%
Шугамын орлогын шимтгэл	3,879,029,479.37	3,682,074,118.69	196,955,360.68	94.9%
Хөнгөлөлттэй зорчилтын шимтгэл	3,951,889,702.78	4,078,763,488.00	(126,873,785.22)	103.2%
Картын борлуулалт	404,133,818.18	841,897,760.77	(437,763,942.59)	208.3%
Шан	89,271,224.91	139,969,259.80	(50,698,034.89)	156.8%
Бусад орлого	155,019,272.73	179,253,000.00	(24,233,727.27)	115.6%
Борлуулалтын өртөг	3,016,991,617.11	3,615,152,741.86	(598,161,124.75)	83.5%
Цэнэглэлтийн шимтгэл	460,909,152.65	397,180,114.21	63,729,038.44	116.0%
Засвар үйлчилгээний зардал	1,848,943,151.76	1,826,130,820.00	22,812,331.76	101.2%
Картын өртөг	602,739,312.70	1,305,617,854.06	(702,878,541.36)	46.2%
Холбооны зардал	104,400,000.00	86,223,953.59	18,176,046.41	121.1%
Нийт ашиг	5,462,351,880.86	5,306,804,885.40	155,546,995.46	
Удирдлага борлуулалтын зардал	4,580,903,454.98	4,314,870,208.63	266,033,246.35	94.2%
Цалин болон бусад	3,413,790,931.16	3,365,023,000.00	48,767,931.16	98.6%
ТУЗ-ын зардал	165,111,680.00	39,556,000.00	125,555,680.00	24.0%
Тээврийн хэрэгсэл болон томилот	130,928,566.00	127,518,000.00	3,410,566.00	97.4%
Зочид төлөөлөгчийн зардал	64,000,000.00	41,947,009.95	22,052,990.05	65.5%
Гаднаас авсан үйлчилгээ	239,903,900.28	192,401,000.00	47,502,900.28	80.2%
Түрээс болон ашиглалтын зардал	85,588,577.54	83,033,089.06	2,555,488.48	97.0%
Холбоо болон хангамжийн зардал	318,069,800.00	357,037,000.00	(38,967,200.00)	112.3%
Бичиг хэргийн зардал	12,780,000.00	13,544,457.78	(764,457.78)	106.0%
Танилцуулга сурталчилгааны зардал	104,200,000.00	75,101,169.04	29,098,830.96	72.1%
Сургалтын зардал	14,000,000.00	745,000.00	13,255,000.00	5.3%
Төлбөрийн шимтгэл	32,530,000.00	18,964,482.80	13,565,517.20	58.3%
Элэгдлийн зардал	2,793,891,034.48	2,724,367,000.00	69,524,034.48	97.5%
Үйл ажиллагааны ашиг	(1,912,442,608.60)	(1,732,432,323.23)	(180,010,285.37)	90.6%
Санхүүгийн ашиг	256,904,095.85	(206,960,195.22)		
Хүүгийн орлого	256,904,095.85	288,676,744.78		
бусад ашиг алдагдал	-	4,843,000.00		
Валютын ханшийн алдагдал	-	(461,938,000.00)		
ОАТ зардал		28,855,940.00		
Татварын өмнөх ашиг, алдагдал	(1,655,538,512.75)	(1,939,392,518.45)		

ГУРАВ.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 195,558.5 мянган төгрөгийн төгрөгийн зөрчил² илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

ДӨРӨВ.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт буюу хөрөнгө оруулагчийн тэглэсэн, өр төлбөрийг дутуу илэрхийлсэн байна.	1	38,384,439.7	-	-	1	38,384,439.7	1	38,384,439.7	-	-	-	-
2	Санхүүгийн байдлын тайланд татварын авлагыг 72,000.0 мянган төгрөгөөр илүү бүртгэж тайлагнасан алдааг залруулж санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэв.	1	72,000.0			1	72,000.0	1	72,000.0				
	Дүн	2	38,456,439.7	-	-	2	38,456,439.7	2	38,456,439.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шатахууны төлбөрийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.	1	35,297.7	-	-	-	-	1	35,297.7	-	-	-	-
2	Нийтийн тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан байна.	1	160,260.8	-	-	-	-	1	160,260.8	-	-	-	-
	Дүн	2	195,558.5	-	-	-	-	2	195,558.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой								
1	Албан хаагчийн дараа төлбөрт утасны төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна.	1	461.1	1	461.1	-	-	-	-
2	Тайлант онд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, байгууллагын төсвийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан буюу тайлангийн хурлын зардалд 76,088.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	76,088.0	-	-	1	76,088.0	-	-
	Дүн	1	76,549.1	1	461.1	1	76,088.0	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 590/АУ260/161

Улаанбаатар хот

НТАГ-2026/030/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар смарт карт ХХК 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин байгууллагын төсвөөс тайлангийн хурлын зардалд 76,088,000.00 (далан зургаан сая наян найман мянга) төгрөгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "энгийн хялбар, чанга хатуу байх", 4.2.3-д "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын төсвөөс тайлангийн хурлын зардал гарган, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллаж биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий захирал Б.Рагчаа, ерөнхий нягтлан бодогч Н.Мөнхтуул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС
Б.ЦОЛМОН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091083



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 243 / АУДИТНЫ

Улаанбаатар хот

НТАГ-2026/030/НА-СТА-ОНӨУГ

Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар смарт карт ХХК-ны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчийн хувийн гар утасны төлбөр 461,100.00 (дөрвөн зуун жаран нэгэн мянга нэг зуу)-н төгрөгийг байгууллагын данснаас төлсөн байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1-д “үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэсэн заалтыг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Байгууллагаас хувийн гар утасны төлбөрт төлсөн 461,100.00 (дөрвөн зуун жаран нэгэн мянга нэг зуу)-н төгрөгийг ерөнхий захирал Б.Рагчаа ерөнхий нягтлан бодогч Н.Мөнхтуул төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг ерөнхий захирал Б.Рагчаа ерөнхий нягтлан бодогч Н.Мөнхтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Е.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС
Б.ЦОЛМОН

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110278

